



**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ДҮРЭМ**

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА, АЖ  
ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ДҮРЭМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**Нэгдүгээр зүйл. Ерөнхий заалт**

- 1.1. Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим (нэ/цаашид “Үндэсний танхим” гэх/ байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үүсгэл санаачилга, гишүүнчлэлийн үндсэн дээр байгуулагдаж, өөрөө удирдах ёсонд тулгуурлан “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай” Монгол Улсын хууль болон энэхүү дүрэмд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа явуулах, төвийг сахисан, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага мөн.
- 1.2. Үндэсний танхим үйл ажиллагаандаа Монгол Улсын “Үндсэн хууль”, “Иргэний хууль”, “Төрийн бус байгууллага”-ын тухай хууль, “Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим”-ын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 1.3. Үндэсний танхим нь төр болон гишүүнийхээ бусдын өмнө хүлээх үүргийг, мөн төр болон гишүүд нь Үндэсний танхимын хүлээх үүргийг тус тус хариуцахгүй бөгөөд шүүх, арбитра нэхэмжлэгч, хариуцагчаар оролцоно.
- 1.4. Үндэсний танхим бүрэн эрхээ хэрэгжүүлэх үүднээс өөрийн төлөөлөгчийн газар, салбараа дотоодод болон гадаад улс оронд нээн ажиллуулж болно.
- 1.5. Үндэсний танхим Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай хуулийн 6.1-д заасан зорилт, бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд банканд харилцах данстай, өөрийн бэлгэдэл, нэр бүхий тамга, тэмдэг, туг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.6. Үндэсний танхим нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлах бөгөөд тус Танхимын салбарыг аймаг, нийслэл, аймаг дунд, тодорхой бүс нутагт байгуулж болно. Үндэсний танхим нь нийслэл Улаанбаатар хотын салбар танхимын эрх, үүргийг давхар гүйцэтгэнэ.
- 1.7. Үндэсний танхимын албан нэр нь монголоор “Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим”, товчилсноор “МҮХАҮТ”, англиар “Mongolian National Chamber of Commerce and Industry” буюу товчилсноор “MNCCI” байна.
- 1.8. Үндэсний Танхимын бүртгэгдсэн албан байршил, шуудангийн хаяг:  
Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 хороо,  
Махатма Гандийн гудамж, МҮХАҮТ-ын байр  
Улаанбаатар 17011, Улаанбаатар шуудан -101011001  
Утас: 976-11-327176, Факс: 976-11-324620  
Цахим шуудан: [chamber@mongolchamber.mn](mailto:chamber@mongolchamber.mn)  
Веб хаяг: [www.mongolchamber.mn](http://www.mongolchamber.mn)

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ ТАНХИМ**

**Хоёрдугаар зүйл. Үндэсний танхимын зорилго, эрх үүрэг**

**2.1. Үндэсний танхимын зорилго, зарчим**

2.1.1. Үндэсний танхимын зорилго нь улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих, худалдаа, үйлдвэрлэлийн орчин үеийн тогтолцоо бий болгох, бизнесийн таатай, тогтвортой орчин бүрдүүлэхэд тус дэмжлэг үзүүлэх, үндэсний эдийн засаг, нийгмийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүднээс санал оруулах, гишүүдийнхээ болон гадаад дотоодын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, жижиг дунд үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжиж үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ, экспортын чадамжийг нэмэгдүүлэх, Монгол Улсын бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.

2.1.2. Үндэсний танхим нь үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэх, аливаа нам, улс төр, шашнаас ангид байж үйл ажиллагаагаа хараат бусаар, бие даан, нээлттэй, ил тодоор явуулан гишүүдийнхээ болон нийт бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төлөөлөн илэрхийлэх зарчмыг баримтлана.

## **2.2. Үндэсний танхимын эрх:**

**Үндэсний танхим нь дор дурдсан эрхтэй байна. Үүнд:**

2.2.1. Үндэсний танхимын гишүүн болон худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн хууль ёсны эрх ашгийг төрийн ба бүх шатны засаг захиргааны байгууллагуудад төлөөлж хамгаалах, үндэсний эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал, дүгнэлт гаргах;

2.2.2. Хөрөнгө оруулалт, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ болон танхимын дотоод үйл ажиллагааг дэмжих зорилгоор Үндэсний танхимын дэргэд төрөл бүрийн сан ажиллуулах, төсөл, хэрэгжүүлэх;

2.2.3. Төрийн болон төрийн бус байгууллага, салбарын ба мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах, төр болон хувийн хэвшил хоорондын түншлэлийг хөгжүүлэх зорилгоор салбарын Зөвлөлүүд байгуулан ажиллуулах;

2.2.4. Эрх хэмжээнийхээ хүрээнд гадаад, дотоодын байгууллага иргэдтэй хэлцэл хийх, харилцаа тогтоох, гэрээ, хэлэлцээр, протокол, санамж бичиг байгуулж хэрэгжүүлэх;

2.2.5. Монгол Улсад болон гадаадад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, түрээслэх, түрээслүүлэх;

2.2.6. Гишүүдээс газрын болон өмчийн харилцаа, бизнесийн орчны холбогдолтой хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар гаргасан санал хүсэлтийг төр, засгийн байгууллагуудад зохих ёсоор уламжлах;

2.2.7. Засгийн газар хоорондын болон гадаад улс, олон улсын байгууллага хоорондын олон улсын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны комиссын хуралд оролцох;

2.2.8. Зохих хууль тогтоомжийн дагуу гадаад, дотоодод хамтарсан худалдаа аж үйлдвэрийн танхим, хамтарсан мэргэжлийн холбоо буюу төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулах, татан буулгах, тэдгээр байгууллагад гишүүнээр элсэх, гишүүнчлэлээс гарах;

2.2.9. Мэргэжлийн боловсролын шүхэр тогтолцоог хэрэгжүүлэх, шинжлэх ухааны ололт, амжилтыг олон нийтэд хүргэхэд дэмжлэг үзүүлэх эрдэм, шинжилгээний болон сургалт, судалгааны байгууллага байгуулах;

2.2.10. Монгол Улс, Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн худалдааны болон бусад төрөл бүрийн баримт бичиг, гэрчилгээ олгох, баталгаа, магадлагаа гаргах;

## **2.3. Үндэсний танхимын үүрэг:**

**Үндэсний танхим нь дараах үүрэгтэй байна. Үүнд:**

2.3.1. Гишүүд болон гадаад, дотоодын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалах, тэдний нэрийн өмнөөс төр, засгийн байгууллагуудтай харилцаж, Үндэсний эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход нөлөөлөх, зөвлөмж, санал дүгнэлт гаргах;

2.3.2. Бизнесийн орчинг судалж, шинжилгээ, үнэлгээ хийх, энэхүү чиглэлээр гарч байгаа хууль тогтоомжид зохих нэмэлт өөрчлөлт оруулах саналыг холбогдох төрийн байгууллагад уламжлах, өргөн барих, хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд оролцох;

2.3.3. Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн буруутай шийдвэр, үйл ажиллагаанаас танхимын гишүүнд учирсан хохирлыг барагдуулахад өмгөөлөл, дэмжлэг үзүүлэх;

2.3.4. Экспортыг дэмжин, дотоодын байгууллага, бизнес эрхлэгчдэд гадаад орны түншүүдтэй ажил хэрэгч хамтын ажиллагааны харилцаа холбоо тогтоох, дотоод гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг шударга тэнцвэртэй байлгахад дэмжлэг үзүүлэх;

2.3.5. Гадаад, дотоодын эдийн засаг, эрдэм шинжилгээний байгууллагууд, бизнесийн салбарын судалгааны баг болон ажил хэргийн групп солилцох, уулзалт ярилцлага, бага хурал, симпозиум, эрдэм шинжилгээ, онол практикийн хурал зохион байгуулж оролцох;

2.3.6. Олон улсын худалдаа, эдийн засаг, бизнесийг дэмжих байгууллагатай харилцаа холбоо тогтоон ажиллах, олон улсын болон хамтарсан худалдаа аж үйлдвэрийн танхимууд, түүнчлэн бүс нутгийн худалдаа, үйлдвэрлэл дэмжих байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, олон талт үйл ажиллагааг хамтран явуулах;

- 2.3.7. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн орчин үеийн ололтыг нэвтрүүлэх, цахим харилцааг Танхимын гишүүн байгууллагууд болон бизнесийн салбарт хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн, идэвхитэй хамтран ажиллах;
- 2.3.8. Эдийн засаг, хамтын ажиллагааны хороо, бизнесийн зөвлөл, танхим, эдийн засаг хөгжлийн төв зэрэг олон улсын байгууллагуудтай хоёр талын эдийн засаг, бизнесийн харилцаа тогтоон хөгжүүлэх;
- 2.3.9. Арбитр эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаан шийдвэрлэх олон улсын ба үндэсний арбитр, эвлэрүүлэн зуучлах төвийг байгуулах ба төвийн үйл ажиллагааны хараат бус бие даасан байдлыг хангаж дэмжлэг үзүүлэх;
- 2.3.10. Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, нийгэмлэг, байгууллагуудад үйлдвэр, үйлчилгээ, худалдаа эрхлэх болон зах зээл, санхүү, валютын арилжааны талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, төрөл бүрийн хэлбэрээр холбогдох ном, сэтгүүл, лавлагааны материал гаргах, гадаадын компаниудад тэдний хүсэлтээр монголын компаниудын найдвартай түншийн лавлагаа өгөх, бүртгэл хөтлөх, гадаадын компаниудын талаар гишүүддээ мэдээлэл өгөх;
- 2.3.11. Гадаад, дотоодын байгууллага, иргэдэд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент авах, ашигтай загвар, бараа, үйлчилгээний тэмдэг бүртгүүлэх болон аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын бусад холбогдох үйлчилгээ үзүүлэн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт явуулах;
- 2.3.12. Монголын экспортын барааны гарал үүслийн гэрчилгээ олгож мөн гарал үүсэл тодорхойлох болон баталгаажуулах талаар холбогдох журам боловсруулан баталж, мөрдөн ажиллах;
- 2.3.13. Хүнд хэцүү нөхцөл /hardship/ болон давагдашгүй хүчин зүйлийг /force major/ баталж, гэрчилгээ олгох;
- 2.3.14. АТА карнейг олгох;
- 2.3.15. Олон улсын үзэсгэлэнгийн товчооны үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, олон улсыг хамарсан арга хэмжээ, “Дэлхийн ЭКСПО” үзэсгэлэн, түүнтэй адилтгах бусад арга хэмжээнд улсаа төлөөлөн оролцох, зохион байгуулах бөгөөд Монгол Улсыг олон улсын хэмжээнд сурталчлах арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулах, гадаад дотоодод төрөлжсөн үзэсгэлэн, яармаг зохион байгуулах;
- 2.3.16. Гадаад, дотоодын байгууллага, иргэдийн захиалгаар экспорт, импортын бараа, бүтээгдэхүүн, түүхий эдэд чанар, тоо хэмжээ, үнэ, иж бүрдлийн хөндлөнгийн магадлан шалгалт хийж, экспертизийн болон бусад сертификат олгох;
- 2.3.17. Аж ахуйн нэгж байгууллага, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, банк санхүү, төрийн эрх бүхий байгууллагуудын хүсэлтээр гишүүн байгууллагуудынхаа талаарх тодорхойлолтыг тэдгээрийн зөвшөөрлийн үндсэн дээр гаргаж өгөх, харин гишүүдийнхээ эрх ашиг, сонирхол, бизнесийн үйл ажиллагааны эсрэг тодорхойлолт гаргахгүй;
- 2.3.18. Хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийг дэмжих зорилгоор төслийн үнэлгээ хийх, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах чиглэлд гадаад, дотоодын байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах;
- 2.3.19. Байгаль орчинд халгүй цэвэр үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг идэвхижүүлэх, энэ чиглэлийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих чиглэлээр гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 2.3.20. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд тал бүрийн туслалцаа үзүүлэх;
- 2.3.21. Үндэсний танхим болон Танхимын жинхэнэ гишүүний хүсэлтийн дагуу төр, иргэний нийгмийн төлөөлөлтэй ажиллах арга барилыг /PR/ хөгжүүлэх, дэмжин урамшуулах үйл ажиллагаа явуулах;
- 2.3.22. Гишүүн байгууллагуудын захиалгаар удирдлага, эдийн засаг, бизнес, хууль, эрх зүйн асуудлаар зөвлөгөө өгөх, урт богино хугацааны сургалт зохион байгуулах, орчуулга хийх;
- 2.3.23. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх хууль эрх зүй, эдийн засгийн орчин бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах, мэргэжлийн боловсролын байгууллага болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг төрөл бүрээр дэмжиж хамтран ажиллах;
- 2.3.24. Гишүүн байгууллагуудынхаа хүний нөөцийн хөгжлийг дэмжих, чадварлаг боловсон хүчнээр хангах зорилгоор бизнес, эдийн засгийн боловсролын чиглэлээр магадлан



итгэмжлэх үйл ажиллагаа явуулах, гишүүдийн дунд хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн сан байгуулж ажиллуулах;

2.3.25. Салбар танхимын хүний нөөцийн бодлогыг сайжруулах, ажилтны ур чадвар, чадавхыг дээшлүүлэн, биеэ даасан чанартай үйл ажиллагааг явуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор төрөл бүрийн сургалт, төсөл, хөтөлбөрт хамруулах;

2.3.26. Бизнесийн үйл ажиллагаандаа амжилт гаргаж буй аж ахуйн нэгж, байгууллага, идэвхи зүтгэл гаргасан хувь хүнийг Үндэсний танхимын шагналаар шагнаан урамшуулах, төр, засгийн одон медаль бусад шагналд тодорхойлох;

2.3.27. Олон улсын худалдааны танхим /ИСС/ болон олон улсын худалдаанд хэвшин тогтсон, энэхүү дүрэмд дурьдагдаагүй бусад түгээмэл үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

2.3.28. Үндэсний танхимын үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулах;

### **Гуравдугаар зүйл. Салбар танхим**

3.1. Аймаг, нийслэл Улаанбаатар хот дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим /цаашид "Салбар танхим" гэх/ нь Үндэсний танхимын үндсэн чиг үүргийг тухайн орон нутагт бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэх албан ёсны салбар мөн.

3.2. Салбар танхим Үндэсний танхимаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

3.3. Үндэсний танхимын Удирдах Зөвлөлөөс баталсан салбар танхимын үйл ажиллагаандаа баримтлах нийтлэг журмыг мөрдөж ажиллана.

3.4. Салбар танхим нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал бүр гарган Үндэсний танхимд хүргүүлнэ.

3.5. Салбар танхимын даргыг тухайн салбар танхимын тэргүүлэгчдийн хурлаас санал болгосны дагуу Үндэсний танхимын Тэргүүлэгчдийн хурлаар батламжилна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГИШҮҮНЧЛЭЛ**

### **Дөрөвдүгээр зүйл. Үндэсний танхимын гишүүнчлэл, гишүүний ангилал**

4.1. Үндэсний танхим нь "гишүүн", "сурвалжлагч" гишүүн, "хүндэт" гишүүнтэй байна.

4.1.1. Үндэсний танхимын гишүүн нь энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрч сайн дурын үндсэн дээр элссэн, холбогдох хуулийн дагуу байгуулагдсан дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн байна. Үндэсний танхимд гишүүнчлэлийн татвараа төлдөг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг Үндэсний танхимын гишүүн, салбар танхимд гишүүнчлэлийн татвараа төлдөг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг салбар танхимын гишүүн гэнэ.

4.1.2. Үндэсний танхимын гишүүн дараах ангилалтай байх ба аль ангилалд гишүүнээр элсэх нь нээлттэй байна. Үүнд:

4.1.2.1. Diamond гишүүн

4.1.2.2. Platinum гишүүн

4.1.2.3. Gold гишүүн

4.1.2.4. Classic гишүүн

4.1.2.5. Гишүүдийн ангиллын болон хүндэт, сурвалжлагч гишүүдийн тухай журмыг

Удирдах зөвлөл батална.

4.1.3. Сурвалжлагч гишүүн Танхимын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэхээ илэрхийлсэн ашгийн бус гадаад, дотоодын байгууллага байна.

4.1.4. Хүндэт гишүүн Танхимын үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн буюу Танхимын эрх ашгийг тууштай хамгаалагч ашгийн бус гадаад, дотоодын байгууллага, иргэн байна.

4.1.5. Танхимын Хүндэт болон Сурвалжлагч гишүүнээр элсүүлэхийг Гүйцэтгэх захирлын санал болгосны дагуу Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж олонхийн саналаар батална. Хүндэт болон Сурвалжлагч гишүүн гишүүний татвар төлөх үүргээс чөлөөлөгдөнө.

4.1.6. Үндэсний танхимын Хүндэт гишүүн Танхимын Их хуралд зөвлөх эрхтэйгээр оролцож болно.

#### **4.2. Гишүүний эрх, үүрэг:**

**Танхимын гишүүн нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:**

- 4.2.1. Харьяалагдах танхимын удирдах байгууллагыг сонгох, түүнд сонгогдох;
- 4.2.2. Үндэсний танхимын Их хуралд оролцож хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар санал бодлоо илэрхийлэх;
- 4.2.3. Үндэсний болон салбар танхимын удирдах байгууллагад ямар ч асуудлаар санал, дүгнэлт, хүсэлт, гомдол гаргах, шийдвэрлүүлэх;
- 4.2.4. Өөрсдийн эрх ашиг, сонирхол, бизнесийн салбар, орон нутгийн харьяалал болон бусад байдлаар зөвлөл, хороо, дэд хороо болон зохион байгуулагдаж Танхимын үйл ажиллагаанд оролцох;
- 4.2.5. Тэргүүн ээлжинд хөнгөлөлттэй нөхцлөөр Үндэсний болон салбар танхимаар үйлчлүүлэх;
- 4.2.6. Үндэсний болон салбар Танхимын үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцох;
- 4.2.7. Гишүүний татварыг тогтоосон журмын дагуу хугацаанд нь төлөх;
- 4.2.8. ХАҮТ-ын тухай хууль болон МҮХАҮТ-ын дүрмийг чанд сахин биелүүлэх;
- 4.2.9. Шударга өрсөлдөөнийг эрхэмлэх;
- 4.2.10. Бизнесийн ёс зүйг чандлан сахих;

#### **4.3. Гишүүнчлэлээс гарах, чөлөөлөгдөх:**

- 4.3.1. Гишүүн гишүүнчлэлээс татгалзсан тухай өргөдлөө Үндэсний болон Салбар танхимд гаргаснаар гишүүнээс чөлөөлөгдөнө. Энэ тохиолдолд гишүүний татварыг буцаан олгохгүй.
- 4.3.2. Гишүүн 2 жил дараалан гишүүний татвараа төлөөгүй буюу энэхүү дүрмийн 4.2.6-4.2.10-д заасан үүргээ биелүүлээгүй бол сануулах бөгөөд ийнхүү сануулснаас хойш 30 хоногийн хугацаанд үүргээ биелүүлээгүй бол гишүүнээс чөлөөлнө.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**Тавдугаар зүйл. Үндэсний танхимын удирдлага**

- 5.1. Үндэсний танхимын удирдах байгууллага нь:
  - 5.1.1. Их хурал
  - 5.1.2. Удирдах Зөвлөл
  - 5.1.3. Тэргүүлэгчид байна.

**Зургадугаар зүйл. Үндэсний танхимын Их хурал**

- 6.1. Үндэсний танхимын удирдах дээд байгууллага нь дөрвөн жилд нэг удаа хуралдах Их хурал байна.
- 6.2. Үндэсний танхимын гишүүдийн тавны нэгээс доошгүй хувийн санал, эсвэл Хяналтын зөвлөлийн шаардлагын үндсэн дээр ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулж болно.
- 6.3. Их хурал хуралдуулах хугацаа, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Удирдах Зөвлөл баталж, хурал эхлэхээс 30 хоногийн өмнө Үндэсний танхимын нийт гишүүдэд албан ёсоор мэдэгдэнэ. Их хурлын талаарх албан мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэнэ.
- 6.4. Үндэсний танхимын гишүүд Их хуралд өөрөө буюу эрх бүхий албан тушаалтнаар дамжуулж оролцоно. Хэрэв тэдгээр нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулж болно.
- 6.5. Үндэсний танхимын Их хурал Үндэсний танхимын гишүүдийн 50 хувь+1 ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцогдох ба асуудлыг ил санал хураах журмаар ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 6.6. Салбар танхимын гишүүд Их хуралд төлөөлөх ардчиллын зарчмаар оролцох ба үүнийг их хурлын ирцэд тооцох бөгөөд мандатын тоогоор саналын эрхтэй байна.
- 6.7. Үндэсний танхимын үйл ажиллагааг зогсоож, татан буулгах асуудлыг Их хурлын нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүйн саналаар шийдвэрлэнэ.
- 6.8. Их хурлын шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр гармагц хүчин төгөлдөр болно.

## **6.9. Үндэсний танхимын Их хурлын эрх, үүрэг:**

**Үндэсний танхимын Их хурал нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:**

- 6.9.1. Үндэсний танхимын үйл ажиллагааны болон хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэж шийдвэрлэх;
- 6.9.2. Үндэсний танхимын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, батлах;
- 6.9.3. Үндэсний танхимын Удирдах Зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийн тоог тогтоон сонгох, батлах;
- 6.9.4. Ерөнхийлөгчийг нэр дэвшигчдээс их хурлаас нууц санал хураалтаар сонгон батлах;
- 6.9.5. Ерөнхийлөгчийн санал хураалтаар нэр дэвшигчдээс 50 хувь+1 саналыг аваагүй тохиолдолд хамгийн өндөр санал авсан 2 нэр дэвшигч дээр дахин санал хураалт явуулж сонгон батална;
- 6.9.6. Үндэсний танхимын үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;

**Долдугаар зүйл. Үндэсний танхимын Удирдах Зөвлөл**

- 7.1. Үндэсний танхимын Удирдах Зөвлөл дөрвөн жилийн хугацаагаар Их хурлаас сонгогдоно.
- 7.2. Удирдах Зөвлөлийн гишүүдийн тоо нь 75 байна. Удирдах зөвлөлийн гишүүн нь дараах шалгууруудыг хангасан байна. Үүнд:
  - 7.2.1. Танхимын гишүүн аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл байна. Хүндэт болон сурвалжлагч гишүүн сонгогдох эрхгүй.
  - 7.2.2. Танхимын гишүүнээр 3-аас доошгүй жил болсон байна.
  - 7.2.3. Гишүүний үүргийн ямар нэг зөрчилгүй байна.
  - 7.2.4. Тодорхой салбарыг төлөөлж чадахуйц байна.
  - 7.2.5. Аж ахуйн нэгжийг орлогч, дэд захирлаас дээш албан тушаалтан буюу итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд төлөөлнө.
- 7.3. Их хурлаас шинээр сонгогдох Удирдах Зөвлөлийн гишүүдийн нэрсийн 23 хүнийг төлөөлөх ардчиллын зарчмаар, үлдэх 52 гишүүнийг Их хурлын гишүүд дундаас шууд ардчиллын зарчмаар тус тус нэр дэвшүүлэн хэлэлцүүлж, ердийн олонхийн саналаар сонгон батална.
- 7.4. Удирдах Зөвлөлийн гишүүд сайн дурын үндсэн дээр ажиллана. Ээлжит их хурлын хооронд Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, хасах, нөхөн томилох асуудлыг Удирдах зөвлөлийн гишүүдийн 2/3 хувийн саналаар шийдвэрлэнэ.
- 7.5. Удирдах зөвлөлийн гишүүний хүлээх үүрэг хариуцлага, урамшуулал, гишүүнээс чөлөөлөх, хасах, нөхөн оруулах асуудлыг зохицуулсан журмыг Удирдах зөвлөлөөс баталж мөрдүүлнэ.
- 7.6. Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн болон Тэргүүлэгчдийн хурлыг даргална.
- 7.7. Удирдах зөвлөл нь төсөв, ажлын албатай байх ба төсвийг Гүйцэтгэх захирал санал болгон Тэргүүлэгчдээр хэлэлцүүлж батлуулна.
- 7.8. Салбар танхимын дарга удирдах зөвлөлийн гишүүн байна.
- 7.9. Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал нар удирдах зөвлөлийн болон тэргүүлэгч гишүүн байна.

## **7.10. Удирдах Зөвлөлийн эрх, үүрэг:**

**Удирдах Зөвлөл нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:**

- 7.10.1. Их хурлуудын хооронд Үндэсний танхимын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;
- 7.10.2. Үндэсний танхимын ээлжит болон ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулах;
- 7.10.3. Үндэсний танхимын жилийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, төсвийг хэлэлцэн батлах, үйл ажиллагааны тайлан ба төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх;
- 7.10.4. Үндэсний танхимын Хүндэт болон Сурвалжлагч гишүүнийг сонгох;
- 7.10.5. Хяналтын зөвлөлийн тайланг Үндэсний танхимын Удирдах зөвлөлийн хуралд танилцуулсны үндсэн дээр Их хуралд оруулах;
- 7.10.6. Үндэсний танхимын дүрэм, үйл ажиллагаа, Удирдах зөвлөл, Тэргүүлэгчид болон Ерөнхийлөгч, Гүйцэтгэх удирдлагын шийдвэр, үйл ажиллагаатай холбогдсон санал, гомдлыг хэлэлцэж шийдвэрлэх;
- 7.10.7. Үндэсний танхимын Тэргүүлэгчдийг сонгох, нөхөн сонгох, чөлөөлөх;

- 7.10.8. Ерөнхийлөгчийг удирдах зөвлөлийн хурлаас чөлөөлөх, удирдах зөвлөлийн гишүүдийн 2/3 хувийн саналаар эргүүлэн татах;
- 7.10.9. Гүйцэтгэх захирлыг Ерөнхийлөгч нэр дэвшигчдийн дундаас сонгон санал оруулж, нууц санал хураалтаар ердийн олонхиор сонгон батлах;
- 7.10.10. Монголын олон улсын ба Үндэсний арбитр, түүний салбар арбитрын дүрэм, зардал тооцох журам, арбитрчдын урамшуулал тооцох журмуудыг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, Дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга, арбитрчдыг томилох, чөлөөлөх;
- 7.10.11. Гүйцэтгэх удирдлагын захиран зарцуулах эрхийн дээд хэмжээг тогтоох;
- 7.10.12. Гишүүний хураамж, үйлчилгээний үнэ тарифыг тогтоох;

#### **7.11. Удирдах зөвлөлийн хурал**

- 7.11.1. Удирдах зөвлөлийн хурал жилд хоёроос доошгүй удаа хуралдана.
- 7.11.2. Удирдах зөвлөлийн хурлын зарыг 7 хоногийн өмнө бүх гишүүдэд хүргэнэ.
- 7.11.3. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг гишүүдэд урьдчилан хүргүүлэх ба гишүүдийн олонхи шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн гишүүний санал болгосон асуудлыг хэлэлцэж болно.
- 7.11.4. Удирдах зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдоролцох боломжгүй болсон бол энэ тухайгаа мэдэгдэж хурлаар хэлэлцэх асуудлуудад өгөх саналаа урьдчилан бичгээр ирүүлж болно. Энэ тохиолдолд түүнийг хуралд ирсэнд тооцно.
- 7.11.5. Удирдах зөвлөлийн хурлыг явуулахдаа 5 хүний бүрэлдэхүүнтэй хурлын тэргүүлэгчийг сонгох ба хурлаас гарсан шийдвэрт Хурлын тэргүүлэгчид гарын үсэг зурж баталгаажуулна.
- 7.11.6. Удирдах зөвлөлийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр нь гармагц хүчин төгөлдөр болно.

#### **Наймдугаар зүйл. Үндэсний танхимын Тэргүүлэгчид**

- 8.1. Үндэсний танхимын Тэргүүлэгчид /цаашид "Тэргүүлэгчид" гэх/ нь Удирдах Зөвлөлийн хурлын хооронд Танхимын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.
- 8.2. Үндэсний танхимын Тэргүүлэгчид 25 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 8.3. Тэргүүлэгчид нь Удирдах Зөвлөлийн гишүүдийн хурлаас ердийн олонхийн саналаар дөрвөн жил хүртэл хугацаатай сонгогдох ба 2 жил тутамд ротацийн зарчмаар тэргүүлэгч гишүүдийн 25 хүртэлх хувийг шинэчлэн сонгож болно.
- 8.4. Тэргүүлэгчдийн хурлыг Ерөнхийлөгч удирдана.
- 8.5. Тэргүүлэгчдийн 50 хувь+1 нь ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцох ба ердийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 8.6. Тэргүүлэгчдийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр нь гармагц хүчин төгөлдөр болно.

#### **8.7. Үндэсний танхимын Тэргүүлэгчдийн эрх, үүрэг:**

##### **Үндэсний танхимын Тэргүүлэгчид нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:**

- 8.7.1. Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх асуудлыг боловсруулж оруулах, тогтоол шийдвэрийг нь хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих;
- 8.7.2. Үндэсний танхимын бүтэц, зохион байгуулалтыг батлах;
- 8.7.3. Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрын дарга, ерөнхий нарийн бичгийн даргын цалин хөлсийг тогтоох;
- 8.7.4. Удирдах Зөвлөлийн хурлуудын хооронд Ерөнхийлөгч, гүйцэтгэх удирдлагаас оруулсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх;
- 8.7.5. Удирдах зөвлөлийн жилийн зардлын төсвийг хэлэлцэн батлах, гүйцэтгэлд хяналт тавих;
- 8.7.6. Ерөнхийлөгчийн цалин, урамшуулал, хангамжийг шийдвэрлэх;
- 8.7.7. Үндэсний Танхимын онцлох аж ахуйн нэгжийн шалгаруулалтын журмыг батлах;
- 8.7.8. Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хүрээнд эрх шилжүүлсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;

#### **Есдүгээр зүйл. Ерөнхийлөгчийн эрх, үүрэг**

- 9.1. Танхимын Ерөнхийлөгч нь удирдах зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэнэ.



## **9.2. Ерөнхийлөгч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:**

- 9.2.1. Удирдах зөвлөлийн болон Тэргүүлэгчдийн хурлыг удирдах;
- 9.2.2. Үндэсний танхимыг гадаад, дотоодод төлөөлөх;
- 9.2.3. Удирдах зөвлөлөөс олгосон болон энэ дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах;
- 9.2.4. МҮХАҮТ-ын үйл ажиллагааг ХАҮТ-ын тухай хууль, энэхүү дүрмийн зорилтод нийцүүлэн удирдан чиглүүлэх;
- 9.2.5. Гүйцэтгэх удирдлагад энэхүү дүрэм болон гэрээгээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд удирдамж, чиглэл өгөх;
- 9.2.6. Гүйцэтгэх удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- 9.2.7. Гүйцэтгэх захиралтай 14 хоногийн дотор гэрээ байгуулах;
- 9.2.8. МҮХАҮТ-ын олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэх;
- 9.2.9. МҮХАҮТ-аас УИХ, Засгийн газар, төрийн болоод төрийн бус байгууллагуудтай гишүүд, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах асуудлаар хамтарч ажиллах;
- 9.2.10. Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчдээс сонгон удирдах зөвлөлд санал оруулан батлуулах, чөлөөлөх, эргүүлэн татах;

## **Аравдугаарзүйл: Гүйцэтгэх удирдлагын эрх үүрэг**

### **10.1. Гүйцэтгэх удирдлагад дараах албан тушаалтнууд орно. Үүнд:**

- 10.1.2. Гүйцэтгэх захирал
- 10.1.3. Дэд захирал
- 10.1.4. Ерөнхий нарийн бичгийн дарга
- 10.2. Гүйцэтгэх захирал нь дэд захирал, ерөнхий нарийн бичгийн даргыг санал болгож тэргүүлэгчдийн хуралд танилцуулж, батлуулна.
- 10.3. Гүйцэтгэх захирал нь дэд захирал, ерөнхий нарийн бичгийн даргатай гэрээ байгуулан ажиллана.
- 10.4. Гүйцэтгэх захирал нь Ерөнхий нягтлан бодогчийг Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр томилно.
- 10.5. Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

### **10.6. Гүйцэтгэх удирдлага нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:**

- 10.6.1. Үндэсний танхимын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн сүлжээ, үйлчилгээний үнэ тарифын талаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөн санал боловсруулж Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулах, хэрэгжүүлэх;
- 10.6.2. Гүйцэтгэх удирдлага нь энэхүү дүрмийн 9.2.7, 10.3 дахь хэсэгт заасан гэрээгээр олгосон эрх хэмжээний хүрээнд гадаад дотоодын байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй харьцах, гэрээ хэлцэл байгуулах, шүүх арбитра нэхэмжлэгч, хариуцагчаар итгэмжлэлгүй оролцох;
- 10.6.3. Олгогдсон эрх хэмжээний хүрээнд тушаал шийдвэр гаргах;
- 10.6.4. Үндэсний танхимын үйл ажиллагааны жилийн тайлан, болон санхүүгийн гүйцэтгэлийг гарган Ерөнхийлөгч, Тэргүүлэгчдэд танилцуулсны үндсэн дээр Удирдах зөвлөлд оруулан хэлэлцүүлэх;
- 10.6.5. Үндэсний Танхимын газар хэлтэс, салбар танхим, салбар арбитра, гадаад дотоодын төлөөлөгчийн газрууд, төсөл хөтөлбөрүүдийг нэгдсэн удирдлагаар хангах;
- 10.6.6. Үндэсний танхимын өмч хөрөнгөд хяналт тавих, захиран зарцуулах;
- 10.6.7. Удирдах зөвлөл, тэргүүлэгчдэд бодлогын чанартай санал хүсэлт тавих, хэрэгжүүлэх, стратегийн санал санаачлага гаргах, мэдээллээр хангах;
- 10.6.8. Гэрээнд заасан бусад эрх

### **Арваннэгдүгээр зүйл. Үндэсний танхимын Хяналтын зөвлөлийн эрх, үүрэг:**

- 11.1. Хяналтын зөвлөл 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр Үндэсний танхимын Их хурлаас дөрвөн жилийн хугацаатайгаар сонгогдоно.
- 11.2. Хяналтын зөвлөлийн даргыг хяналтын зөвлөлийн гишүүдээс нууцаар санал хурааж олонхийн саналаар сонгоно.

11.3. Хяналтын зөвлөл нь Удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтэд жилд нэгээс доошгүй удаа шалгалт хийж дүгнэлт гаргана.

11.4. Үндэсний хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох явцад хяналт тавьж, хөндлөнгийн аудитын үйл ажиллагаа, тэдгээрээс танхимын удирдлагад өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилтийг хянана.

11.5. Танхимын жилийн санхүүгийн тайланг шинжилж, санхүүгийн тайлангаа удирдах зөвлөл болон тэргүүлэгчдэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, танхимын тэргүүлэгчдээр батлуулахаар оруулсан төсөв, төлөвлөгөөний талаар танхимын удирдлагад жил бүр зөвлөмж хүргүүлнэ.

11.6. Танхимын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааны бодлого, процедурын сонголт, сонгосон бодлогын даган мөрдөлт, танхимын хөрөнгийн болон мэдээллийн аюулгүй ажиллагааны хамгаалалтыг судалж үнэлэлт өгч болно.

11.7. Танхимын дэргэд хэрэгжүүлж байгаа төслүүд, танхимын үүсгэл санаачлагаар байгуулсан сангуудын үйл ажиллагаатай танилцаж, шаардлагатай бол холбогдох арга хэмжээ авахыг танхимын удирдлагад санал болгоно.

11.8. Танхимын удирдлагын дотоод хяналтын талаар гаргасан журам, дотоод хяналтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай танилцаж холбогдох арга хэмжээ авахыг танхимын удирдлагад санал болгоно.

11.9. Хяналтын зөвлөл 4 жилийн хугацаанд хийсэн хяналтын зөвлөлийн тайланг нэгтгэж Удирдах зөвлөлд танилцуулж Үндэсний танхимын Их хуралд тайлагнана.

11.10. Хяналтын зөвлөл нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх төсөвтэй байж болно. Төсвийг тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж батална.

11.11. Хяналтын зөвлөл эрхлэх үйл ажиллагаандаа удирдлага болгох дотоод журамтай байна. Дотоод журмыг Удирдах зөвлөлийн хурлаар батална.

11.12. Хяналтын зөвлөл Танхимын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, касс, эд хөрөнгийн тооцоо бүртгэл, салбар танхимын үйл ажиллагааг 2 жилд нэгээс доошгүй удаа шалгана.

11.13. Хяналтын зөвлөл ээлжит бус Их хурал хуралдуулах талаар Удирдах Зөвлөлд санал оруулах эрхтэй.

## **ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД**

### **Арванхоёрдугаар зүйл. Үндэсний танхимын өмч, хөрөнгө**

12.1. Үндэсний танхимын өмч хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө тэдгээртэй адилтгах бусад активаас бүрдэнэ.

12.2. Үндэсний танхимын өмч хөрөнгө нь гишүүдийн татвар, гадаад, дотоодын байгууллагуудын хандив, зээл, тусламж, Монголын болон гадаад орнуудын Засгийн газар, олон улсын байгууллагаас бэлэглэсэн эд хөрөнгө, сан, өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого, тэдгээртэй адилтгах хөрөнгөнөөс бүрдэнэ.

12.3. Үндэсний танхим нь Танхимын хууль болон Төрийн бус байгууллагын тухай хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлж өөрийгээ санхүүжүүлнэ.

12.4. Үндэсний танхимын өмч, хөрөнгө халдашгүй байна.

### **Арван гуравдугаар зүйл. Үндэсний танхимаас төр, засгийн болон бусад байгууллагатай харилцах**

13.1. Монгол Улсын хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн байгууллагаас Танхимын үйл ажиллагаанд, Танхимаас төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй.

13.2. Үндэсний танхим нь төрийн баримталж байгаа эдийн засаг, нийгмийн бодлогыг дэмжин дэлгэрүүлэх, гадаад, дотоодод тайлбарлан таниулах, хэрэгжүүлэхэд туслах, тодорхой асуудлаар Үндэсний танхимын гишүүд, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн, нийтлэг эрх ашиг, сонирхлыг илэрхийлэн хамгаалах үүднээс төр, засгийн байгууллагатай зөвшилцөх, хэлэлцээ хийх, шаардлага тавих, мэдэгдэл гаргах, санал зөвлөмж хүргүүлэх зэргээр хамтран ажиллана.

13.3. Үндэсний танхим нь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд УИХ, Засгийн газрын холбогдох комисс, зөвлөл, хороодод орж ажиллах, Яам, агентлагийн сайд, даргын зөвлөл, аймаг орон нутгийн ИТХ, Засаг даргын

байгуулсан бизнес, эдийн засаг, хувийн хэвшлийн үйл ажиллагаатай холбоотой орон тооны болоод орон тооны бус хороо, зөвлөл, ажлын хэсгүүдэд төлөөллөө оруулан ажиллуулна.

13.4. Үндэсний танхим бусад төрийн бус байгууллага, худалдаа, үйлдвэрлэлийн нийгэмлэг, холбоод, Танхимтай харилцахдаа хууль дээдлэх, харилцан хүндэтгэх, дэмжин туслах, шударга байх, хамтран ажиллах зарчим баримтална.

13.5. Үндэсний танхим нь өөрийн болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан үйл ажиллагаагаа гишүүд, олон нийт бизнес эрхлэгчдэд болон төр засагт хүргэнэ.

**Арван дөрөвдүгээр зүйл. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимыг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах**

14.1. Үндэсний танхимын үйл ажиллагааг зогсоож, татан буулгах асуудлыг Үндэсний танхимын Их хурлаар шийдвэрлэнэ.

**Арван тавдугаар зүйл. Дүрэм хүчин төгөлдөр болох**

15.1. Энэхүү Дүрэм нь Их хурлаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.